

“Цаг уурын хүндрэлийг даван туулж байгаа байдал” өрхийн панел судалгаа Увс аймагт 2012 оны 5 сараас эхлэн 2015 оны 4 сар хүртэл 3 жилийн хугацаанд явагдах бөгөөд мэдээлэл цуглуулалт 3 урсгалтай байга. Сонгогдсон өрх бүр 3 удаа судалгаанд оролцоно. Эхний судалгаанд хамрагдсан тухайн өрх 12 сарын дараа, 24 сарын дараа дахин судалгааны ярилцлагад хамрагдана. Судалгааны гол зорилго нь Монгол улсын баруун аймгуудын өрхийн аж байдалд ган, үер, зуд хэрхэн нөлөөлдөг, өрхүүд ган, зуд болон бусад таагүй үйл явдлуудыг даван туулахын тулд ямар арга хэмжээ авдаг, таагүй үйл явдлууд өрхийн амьжиргаанд хэрхэн нөлөөлдөг талаар мэдээлэлтэй болох, шинжилгээ хийх явдал юм. Энэхүү төслийн үр дүн нь өрхүүд таагүй үйл явдлыг даван туулах чадавхийг хэрхэн сайжруулах талаар бодлого боловсруулагч нарт чухал мэдээлэл болох юм.

Увс аймгийн хэмжээнд жилийн хугацаанд 74 нэгжийн 592 өрх хамрагдсан байгаа. Манай аймагт сард дунджаар 40-56 өрхөөс судалгааны мэдээлэл цуглуулж байгаа. Үүнээс аймгийн төвд 37 нэгжийн 296 өрх, сумын төвд 10 нэгжийн 80 өрх, Хөдөө 27 нэгжийн 216 өрх тус тус хамрагдсан билээ. Тус судалгаанд Баруунтуруун, Давст, Завхан, Малчин, Наранбулаг, Өндөрхангай, Хяргас, Бөхмөрөн, Зүүнхангай, Өлгий, Өмнөговь, Сагил, Тариалан, Тэс, Ховд, Цагаанхайрхан, Улаангом гэх мэт сумууд хамрагдсан байна. Харин Улаангомын 1,2,3,4,5,6,7,9,10,11-р багууд хамрагдсан байна.

Мөн судалгаанд хамрагдсан сум бүрээс бараа бүтээгдэхүүний үнийн мэдээ сар бүр, сумын асуулга зэрэг судалгаануудыг жилд нэг удаа авна.